**МОНГОЛ УЛСЫН СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 08 сарын 27 өдөр Дугаар А/114 Улаанбаатар хот

## Ажлын хэсэг шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6.2, 9.8 дахь хэсгийг үндэслэн, Улсын Их Хурлын 2024 оны 46 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2024-2030)"-ний 9.2.1.1, 9.1.3.1-д заасныг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Авлигыг үл тэвчих үзлийг олон нийтэд төлөвшүүлэх, Амьдралын хэв маяг, үзэл бодол, үнэт зүйлс, соёлд тулгуурлан соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулж үр нөлөөг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай.

| | |
|---|---|
| Ажлын хэсгийн дарга: | Н.Мөнхзул /Соёл, урлагийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга/ |
| Гишүүн: | Н.Ариунболд / Хүүхэд, залуучуудын театрын захирал/ |
| | З.Баянзул /Улсын Хүүхэлдэйн театрын захирал/ |
| | Д.Алтанхуяг /Дуурь бүжгийн эрдмийн театрын захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч/ |
| | Ц.Эрдэнэбаатар /Богд хааны ордон музейн захирлын албан үүргийг түр гүйцэтгэгч/ |
| | Б.Ичинхорлоо / Үндэсний номын сангийн захирал/ |
| Нарийн бичгийн дарга: | Д.Оюунжаргал /Хууль,эрх зүйн хэлтсийн Эрх зүйн мэдээллийн сан хариуцсан ахлах мэргэжилтэн/ |

2. Ажлын хэсгийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан батлуулж 2025 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор, тушаалын хэрэгжилтийг 2025 оны 12 дугаар сарын 15-ны дотор тус тус тайлагнаж ажиллахыг Ажлын хэсэг /Н.Мөнхзул/-т үүрэг болгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны "Ажлын хэсэг байгуулах тухай" А/68 дугаар тушаалыг хүчингүй болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.ДАВААЦЭРЭН

АТА12931 6594204 9024070548

1419002053

БАТЛАВ

СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ДАВААЦЭРЭН

2025 оны . . . дугаар сарын . . . өдөр

# СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН ЯАМНААС 2025 ОНД ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДАЛД НӨЛӨӨЛӨХ АЖИЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Авлигын эсрэг үйл ажиллагаа | Үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Төсөв | Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хариуцах нэгж | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Үндсэн | Хамтран хэрэгжүүлэх |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | НЭГ. БОГИНО ХЭМЖЭЭНИЙ КИНО /КОНТЕНТ/ ХИЙХ | | | | | | |
| 1. | Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 9.1.3.1. Амьдралын хэв маяг, үзэл бодол, үнэт зүйлс, соёлд тулгуурлан соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулж, үр нөлөөг нэмэгдүүлэх | 2025 | 30 сая | -Хүүхдийн шударга байдлыг нэмэгдүүлэх | ТЗУГ СУБХЗГ | Бусад газар, хэлтэс, харьяа байгууллага |
| | | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 9.2.1 Үндэсний контентыг | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | бүтээж, авлигыг үл тэвчих үзлийг олон нийтэд төлөвшүүлнэ. | | | | | |
| | | Дэлхийн хүүхдийн өдрийг угтан “Гэр бүл-Соёлын анхдагч орчин” арга хэмжээ зохион байгуулах | 2025 | - | -Сайн хүүхэд байсны давуу талыг ойлгуулах. | ТЗУГ СУБХЗГ | Бусад газар, хэлтэс, харьяа байгууллага |
| | | Жил бүр зохион байгуулагддаг “Соёлын бүтээлч сар” аяны хүрээнд АТГ-тай хамтран арга хэмжээ зохион байгуулах | 2025 | - | Шударга хүн болон төлөвшихөд нөлөөлөх. | ТЗУГ СУБХЗГ | Бусад газар, хэлтэс, харьяа байгууллага |